



НИЙСЛЭЛИЙН СОЁЛЫН ТӨВ ӨРГӨӨНИЙ 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2023 ОН

Гарчиг

1. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүн3
2. Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, үр дүн3-5
3. Байгууллагын үйл ажиллагааны үр дүн5-53
4. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал53-57
5. Цаг үеийн шаардлагаар хийсэн ажлын үр дүн57-66

СОЁЛЫН ТӨВ ӨРГӨӨНИЙ 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ: БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ.

Өргөө нь Монгол Улсын хууль, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 хөтөлбөр, Улсын Их Хурлаас 2012 онд баталсан “Төрөөс соёлын талаар баримтлах бодлого, Засгийн Газраас батлагдсан төсөл хөтөлбөр, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан “Нийслэлийн хүн амд үзүүлэх соёл, урлагийн үйлчилгээний нэр төрлийг олшруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, соёл урлагийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх” зорилтууд, байгууллагын үйл ажиллагаанд мөрдөхөөр батлагдсан дүрэм, журам, зааврыг хэрэгжүүлж ирлээ. Тухайлбал:

- Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар төрийн үйлчилгээний албанд тавигддаг зарчим, шаардлага болон холбогдох заалтууд, нийслэлийн өмчийн эд хөрөнгийг бэлтгэх, бүртгэх, ашиглах, хамгаалах, түрээслэхэд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Архивын тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, НИТХ-ын тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж ирлээ.
- “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх, нийслэлийн хүн ам, нийгэм, эдийн засгийн хөгжил, байгаль орчны тэнцвэртэй байдал, засаглалыг сайжруулахад чиглэсэн нэгдмэл цогц, харилцан уялдаатай, давхардалгүй, хүртээмжтэй, бүх нийтийн оролцоог хангасан байх зарчмуудыг баримтлан “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” төлөвлөлтийн баримт бичигт дэвшүүлсэн зорилтыг байгууллагынхаа үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллаж байна.

ХОЁР: ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

2.1. Байгууллагын үйл ажиллагааг тайлагнах хугацаа

Байгууллагын үйл ажиллагааны тайланг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”-ын хавсралтын дагуу бодлогын баримт бичиг, захирамжлалын баримт бичгийн хэрэгжилтийг хагас, бүтэн жилийн байдлаар гаргаж, холбогдох материалын хамт НЗДТГ-ын Хяналт Шинжилгээ Үнэлгээний хэлтэст хүргүүлж хэвшсэн болно.

2.2. Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилт.

Засгийн газрын 2017 оны 243 дугаар тогтоол, Засгийн газраас 2018 онд баталсан “Төрийн албаны сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах” 258 тогтоол, 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасны хугацааны нэмэгдэл олгох журам”, “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”, “Төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох нийтлэг журам”, Төрийн албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”, Засгийн газрын 2023 оны 240 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт, 241 дүгээр тогтоолын 9 дүгээр хавсралтын хэрэгжилтийг хангаж, ажиллагаандаа хэвшил болгон ажиллаж ирлээ.

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл ахуйн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Засгийн газрын 2017 оны 243 дугаар тогтоол, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын холбогдох заалтуудыг үндэслэн Соёлын Төв Өргөөний “Албан хаагчдын дагаж мөрдөх хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм”, албаны “Албан хаагчдын дагаж мөрдөх хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны журам”-ыг баталж, хэрэгжүүлж хэвшлээ. Сангийн слесарь 4, бохирын слесарь 1, цахилгаанчин 1, гагнуурчин 1, барилгын засварчин 1 нийт 10 инженер техникийн ажилтныг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлээр ханган ажиллалаа.

2. Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм” холбогдох заалтыг байгууллагын дотоод журамд тусгаж үйлчилгээний онцлогийг харгалзан албан хаагчдын ёс зүйн дүрмийг боловсруулан гаргаж, мөрдөн ажиллаж байна.

3. Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын хэрэгжилтийг хангаж, 2023 онд өндөр насны тэтгэвэр тогтоолгосон 1 албан хаагчид IV улиралд 16,477,500 төгрөгийг, гачигдлын улмаас 6 албан хаагчдын ар гэрт 3,000,000 төгрөгийн тусламж, 1000,000 төгрөгийн буцалтгүй тусламж 2 албан хаагчид, “Эх үрсийн баяр”-ийн өдөр албан хаагчдын хүүхдүүдийг баярлуулах бэлгэнд 2,838,400 төгрөг, байгууллагаас гавьяаны амралтанд гарсан 31 өндөр настнуудад хүндэтгэл үзүүлж 3,100,000 төгрөг нийт 26,415,900 төгрөгийг олгосон байна

4. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж 2023 онд нийт 159 шилэн дансны мэдээлэл оруулахаас жилийн эцсийн байдлаар 159 мэдээлэл байршуулан ажиллалаа.

5. 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хөндлөнгийн аудитыг Нийслэл дэх Төрийн аудитын газраар хийлгэж, **“Санхүүгийн тайлангаа холбогдох хууль,**

санхүүгийн тайлангийн олон улсын стандарт, нягтлан болох бүртгэлийн олон улсын стандарт, түүнд нийцүүлсэн холбогдох заавар журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн, санхүүгийн зөрчилгүй” гэсэн дүгнэлт авсан. 2023 оны жилийн эцсийн байдлаар санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга бат, гүйцэтгэлийн хариуцлагын талаарх хууль тогтоомжийг мөрдөж, ажилласан. Мөн “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн дагуу захирал, ахлах нягтлан бодогч нар хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд хүргүүлсэн болно.

ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН:

3.1. Хүн амд үзүүлэх соёл урлагийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд хийсэн ажил, үр дүн.

“Нийслэлийн хүн амд соёл урлагаар үйлчлэх үйлчилгээний нэр төрлийг олшруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх” үүргийн хүрээнд **239** удаагийн урлагийн тоглолт, хурал зөвлөгөөн, бусад үйл ажиллагаа явагдаж 226000 гаруй иргэдэд соёлын үйлчилгээ үзүүлсэн Тухайлбал:

- Х түц продакшны ээлжит уран бүтээл болох “Зохиолгүй Амьдрал” инээдмийн драмын жүжиг
- Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад явагдаж буй НҮБ-ын энхийг сахиулах “UNMISS” ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн XI ээлжийн цэргийн багийн бие бүрэлдэхүүнд Төрийн болон Батлан хамгаалах салбарын одон, медаль гардуулах ёслолын ажиллагаа
- Монгол Улсад орчин цагийн уул уурхайн салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойд зориулсан “Монголын Уул Уурхай–100 Жил” баярын хурал, хүндэтгэлийн тоглолт
- Төрийн шагналт, Ардын жүжигчин, ХХ зууны манлай циркийн жүжигчин, уран нугараач Б.Норовсамбуу гуайн 75 насны ойд зориулсан бүх циркчдийн хүндэтгэлийн тоглолт
- Хайрын шүлгийн “Цагаан Уул” яруу найргийн наадам
- Нийслэлийн ерөнхий боловсролын 1-р дунд сургуулийн “Түүхт 100 Жилийн Ой”-д зориулсан баярын хурал, хүндэтгэлийн тоглолт
- Монголын хөгжмийн зохиолчдын холбооноос зохион байгуулсан оны шилдэг дуу шалгаруулах “Морин Хуур-35” хөгжмийн наадам
- Мөрөөдлийн театрын хамтлагийн “Шөнө буусан аадар” драмын жүжиг
- Ерөнхий Боловсролын Сургуулийн ахлах ангийн сурагчдад зориулан зохион байгуулж буй “Шинэ Алхам–2023” мэргэжил сонголтонд зөвлөх өдөрлөг
- Монгол Улсын Ардын Жүжигчин, дуурийн дуучин А.Долгорын уран бүтээлийн “Эгшиглэнт–50 жил” хүндэтгэлийн тоглолт
- Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Засгийн газрын гишүүд оролцсон “Шинэ Сэргэлтийн Бодлого”-ын талаар Зэвсэгт хүчний бүх шатны бие бүрэлдэхүүнтэй хийх уулзалт

- Хууль Зүйн Яам, Монголын Залуучуудын Холбоо хамтран зохион байгуулж буй Зэвсэгт хүчний 102 жилийн ойн баярт зориулсан “Эх Орны Төлөө” мөрдөст чуулгуудын нэгдсэн хүндэтгэлийн тоглолт
- Соёлын Аялал Жуулчлалын Олон Улсын Нийгэмлэгээс зохион байгуулсан Улаанбаатар, Дорноговь, Багануур, ОХУ-ын Иркутск, Ангарск, Улан-Үдэ, Себеровбайкальск, Иркутская область, Забайкальский край газруудаас оролцсон шилдгийн шилдэг хүүхдүүдийн “Алтан Гадас” наадам,
- Соёлын Яам, Нийслэлийн Соёл Урлагийн Газараас Нийслэлийн 9 дүүргийн 204 хорооны анхан шатны нэгжийн албан хаагчдад зориулсан “Монгол Улсын Баримтат Өвийн Бүртгэл Мэдээллийн Нэгдсэн Жагсаалтад Өвийг Бүртгэх Аргачлал” сэдэвт хүний нөөцийг чадавхжуулах сургалт
- “Moon dance Mongolian’s” ТББ-аас зохион байгуулж буй “Dancesport family-2023” хамтлагуудын аварга шалгаруулах тэмцээн
- Дуучин Л.Нарангэрэлийн “Магнаг цэнхэр дэлхий” уран бүтээлийн тоглолт
- ЦДБЭЧ-ийн дэд хурандаа Р.Өнөржаргалын “Яруу цаг дор” уран бүтээлийн тайлан тоглолт
- “Эрдэнэс Таван толгой” ХК-ийн үйл ажиллагааны хурал
- ЦДБЭЧ-ийн бүжигчин Энхжаргалын “Хязгааргүй хүсэл” уран бүтээлийн тоглолт
- “Ард санхүүгийн нэгдэл”-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал
- Сэтгэмж Цогцолбор Сургуулийн 2022–2023 оны хичээлийн жилийн “Сэтгэмж-50” багш сурагчдын нэгдсэн тайлан тоглолт
- Соёлын тэргүүний ажилтан, ХЦДБЧ-ын дуучин Х.Хашийн “Мөнхөд Эгшиглэнэ” уран бүтээлийн тоглолт
- Логрифм Сургуулийн 2022–2023 оны хичээлийн жилийн “Гэрэл Цацарсан Хүүхэд Нас” бага ангийн сурагчдын нэгдсэн тайлан тоглолт
- МУГЖ жүжигчин, дуучин Д.Сосорбарамын уран бүтээлийн “Эрх Нялх Аялгуу” тоглолт
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдаж буй олон улсын сувилагчдын өдөрт зориулсан “Бидний Сувилагч-Бидний Ирээдүй” ёслол хүндэтгэлийн арга хэмжээ.
- Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн 2022–2023 оны хичээлийн жилийн төгсөгчдийн “Эрдмийн Баяр” төгсөлтийн арга хэмжээ
- Хобби Сургуулийн 2022–2023 оны хичээлийн жилийн “Хаврын Баяр-2023” суралцагчдын нэгдсэн тайлан тоглолт
- Монгол Улсын Консерваторийн Бүжиг Циркийн Мэргэжлийн Сургуулийн ардын бүжгийн 12г ангийн сурагчдын “Хөгөнд Амилсан Дэг” төгсөлтийн тайлан тоглолт
- ЗГХЭГ-аас зохион байгуулсан “Монгол Улсын Үндсэн Хуульд Оруулах Өөрчлөлт, Өнөөгийн Нөхцөл Байдал, Шаардлага” сэдвээр төрийн албаны албан хаагчидтай хийх хэлэлцүүлэг.
- Соёл Урлагийн Их Сургуулийн оюутнуудын 2022–2023 оны хичээлийн жилийн “Монгол Эрдэнэ-2023” нэгдсэн тайлан тоглолт
- Сэтгэмж Цогцолбор Сургуулийн 2022–2023 оны хичээлийн жилийн “Сэтгэмж-50” багш сурагчдын нэгдсэн тайлан тоглолт

- Монголын Балетын Хөгжил Сангийн дэргэдэх Монголын Балетын Үндэсний Сургуулийн сурагчдын “Хаврын Баяр-2023” балетын тоглолт
- Зүүн Азийн Залуучуудын Наадмын зохион байгуулах хорооноос зохион байгуулж буй “Улаанбаатар 2023” сайн дурын ажилтнуудад зөвлөгөө өгөх хурал.
- “MPC” ХХК-аас зохион байгуулсан “Нобелийн шагналтны лекц” арга хэмжээ.
- Нийслэлийн инновацийн газраас зохион байгуулсан “DEV Sunmeet” арга хэмжээ.
- ХХЕГ-аас зохион байгуулж “Хилчин эмэгтэйчүүдийн зөвлөгөөн”
- Хүмүүнлэгийн Ухааны Их Сургуулийн 2019–2023 оны төгсөгчдийн “Бүтээлч Оюун Ухаан Таны Ирээдүйн Амжилт” төгсөлтийн ёслолын үйл ажиллагаа
- Алсын Хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгасан “Хүүхдийн Хоол” үндэсний чуулган
- Монгол Тэмүүлэл Сургуулийн 2022–2023 оны хичээлийн жилийн “Эрдмийн Баяр” төгсөлтийн арга хэмжээ
- Олон Улсын Улаанбаатар Их Сургуулийн 2022–2023 оны хичээлийн жилийн төгсөгчдийн “27 дахь Төгсөлтийн Баяр”-ын арга хэмжээ
- Чингис хаан одонт Монгол улсын Морин хуурын чуулгын “Best of playing love”
- Нийслэлийн Засаг Дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Сумъяабазар Сонгино Хайрхан дүүргийн ахмадуудтай хийх уулзалт, Улаанбаатар Театрын “Colors Of Mongolia – 2023” тоглолт
- Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газраас олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Их Хотын Бүсгүйчүүд-2023” хүндэтгэлийн арга хэмжээ
- Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазарын зохион байгуулж буй Зэвсэгт хүчний 102 жилийн ойн баярт зориулсан “Тангарагтны Дуулал” тоглолт
- Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлсэн Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд “Хөдөөгийн Сэргэлт” үндэсний чуулган.
- Нийслэлийн МАН-ын 98 жилийн ойн баярын хурал.
- Соёл Урлагийн Их Сургуулийн оюутнуудын 2022–2023 оны хичээлийн жилийн “Монгол Эрдэнэ-2023” нэгдсэн тайлан тоглолт
- Монгол Улсын Их Хурлын дарга Занданшатар “Эрх Зүйн Шинэчлэл” сэдвээр төрийн албаны албан хаагчидтай хийх хэлэлцүүлэг
- ЗГХЭГ-аас зохион байгуулж буй “Монгол Улсын Үндсэн Хуульд Оруулах Өөрчлөлт, Өнөөгийн Нөхцөл Байдал, Шаардлага” сэдвээр төрийн албаны албан хаагчидтай хийх хэлэлцүүлэг
- Олон Улсын Хүүхдийн Эрхийг Хамгаалах өдөрт зориулсан Нийслэлийн бизнес хөгжлийн газраас зохион байгуулсан “Хөгжлийн Харандаа” инновацын үзэсгэлэн арга хэмжээ.
- Монгол улсад анх удаа зохион явагдсан Зүүн азийн залуучуудын наадмын Е-спортын тэмцээн
- БНХАУ-лс, Өвөр монголын өөртөө засах орны соёлын өдрүүд “ХЯТАД ОРНЫГ ТАНИН МЭДЭХ” тоглолт арга хэмжээ.
- ТӨХК ДЦС-4 “Монгол төрийн их голомт” хүндэтгэлийн тоглолт

- “Дэлхийн шилдэг зохиолчдыг Монголд” төслийн хүрээнд Хятадын орчин цагийн нэрт зохиолч Үй Хуагийн Монголын уншигчидтай хийх уулзалт, лекцийн арга хэмжээ
- Олон улсын театрын “Гэгээн Муза 17” Академийн шагнал гардуулах ёслолын арга хэмжээ.
- “Төрийн тусгай албан хаагчдын эмнэлгийн 90 ЖИЛИЙН ОЙН ХҮНДЭТГЭЛИЙН” арга хэмжээ
- Д.Нанжидын нэрэмжит “Биелгээ” Тэнгэрийн хүүхдүүдийн ОУ-ын анхдугаар уралдаан.
- Эмоци продакшны “Нэгэн зуны цэцэг” жүжиг
- . БЦДБЭЧуулгын бүжигчин Ууганбаярын Уухайн түрлэгт бүжгэн дэг мину уран бүтээлийн тоглолт
- Ньюанс хамтлагийн дуучин “SOLO CONCERT” Д.Дүйнхэржавын уран бүтээлийн тоглолт
- Ерөнхийлөгчийн тамгын газар, БХЯамнаас зохион байгуулсан БНӨСУ-д явагдаж байгаа энхийг сахиулах UNMISS ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн МУЗХ-ний XII ээлжийн мотобуудлагын батальонд шагнал гардуулах ёслолын үйл ажиллагаа.
- Монголын Хөгжмийн Зохиолчдын Холбооноос зохион байгуулсан Алтан намар 2023 хөгжмийн наадам..
- Монголын зохиолчдын холбооноос зохион байгуулсан “Болор цом 41” яруу найргийн наадам.
- Чингис хаан одонт, Хөдөлмөрийн баатар, ТШ Б.Шарав. “Сэрсэн тал 39” уран бүтээлийн тоглолт
- Инээмсэглэл хамтлагийн уран бүтээлийн Инээмсэглэл тоглолт
- “Монгол улсад мал эмнэлэг, үржлийн албаны нээлттэй хаалганы өдөрлөг Мал эмнэлгийн 100 жилийн үйл ажиллагаа.
- НЗДТГазраас зохион байгуулсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын оролцоо” сэдэвт зөвлөгөөн.
- МУГЖ дуучин Ө.Уянгын “Зул сарын баяр” уран бүтээлийн тоглолт.
- Таван толгой түлш ХХК-ны бүтээн байгуулалтын тайлангийн хурал.
- НЗДТГ, НСУГазраас зохион байгуулсан Азийн хотуудын урлаг гар урлалын наадам.
- НЗДТГ, НБХ, Нийслэлийн ахмадын хорооноос зохион явуулсан ОУ-ын ахмадын баяр.
- ОХУ, Буриадын хамтын ажиллагааны хүрээнд Орос Монголын найрамдал хамтын ажиллагааны 63 дахь өдрийн “Найрамдал” тоглолт арга хэмжээ
- Нийслэл хотын 384 жилийн ойн хүрээнд Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, Ардын жүжигчин Дагвын Лувсаншаравын нэрэмжит Хүүхдийн найрал дууны шилдэг хамтлаг шалгаруулах 29 дэх удаагийн наадам
- Нийслэл хот байгуулагдсан 384 жилийн ойн хүндэтгэлийн баярын тоглолт
- Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Нямбаатарын зохион байгуулсан Тээвэр ложистикийн оновчтой шийдэл, түгжрэлийг

бууруулах сэдвээр Нийслэлийн аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөл иргэдтэй уулзах уулзалт.

- Соёлын яамны Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн сарын хүрээнд Их дээд сургуулиудын дунд зохиогдсон Дэвжээ урлагийн наадам
- МУ-ын филармонийн SNOW MELODY “JOJO’S CHRISTMAS SPECIAL” зэрэг уран бүтээлийн тоглолт үйл ажиллагаанууд болохоос гадна МУИС, ХААИС, СЭЗИС, ШУТИС, ХИС, Сити дээд сургууль, МУБИС зэрэг их дээд сургуулиудын төгсөлтийн баяр диплом гардуулах ёслолын үйл ажиллагаанууд тус тус болж өндөрлөсөн.



























3.1.1.Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр дэх /1.1.1/ “Цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна”, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр дэх /2.6.3/ “Хотын соёлыг төлөвшүүлж түгээн дэлгэрүүлэх ажлыг бүх шатанд зохион байгуулна” зорилтуудын хүрээнд дараах ажлуудыг хийж хэрэгжүүллээ.

3.1.1.1 Ковид-19 цар тахлын идэвхтэй үе буурсан ч үйлчлэгч нар нь өөрсдийн хариуцсан талбайдаа өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээг зориулалтын ариутгалын бодисоор хийхээс гадна үзэгчдийн их танхимын хивсэнцэр, 3-р давхрын фойены хивсэнцрийн өнгөлгөө, “А”, “Г” байрны подвалд бүх нийтийн их цэвэрлэгээг 14 хоногт 1 удаа тогтмол хийж, өрөө тасалгаанд ариутгалын бодистой цэвэрлэгээг өдөрт 2 удаа хийж, шат хаалганы бариул зэрэг хүн их хүрдэг хэсгийг ариутгалын бодистой уусмалаар байнга арчиж, цэвэрлэж байна

2023 оны 02 дугаар сарын 15, 12 дугаар сарын 08,17-ны өдрүүдэд “А”, “Г” байранд “Мастер ариутгал” ХХК-аар ариутгал, халдваргүйжүүлэлтийг хийж ажилласан.





3.1.1.2 Үзэгчдийн үзвэр үзэх соёлыг нэмэгдүүлж, үзвэрийн танхимд соёлтой үйлчлүүлэх, үзвэрийн танхимд ус ундаа, хүнсний бүтээгдэхүүн хэрэглэхийг хориглосон тухай “Аудио бичлэг”-ийг тоглолт арга хэмжээ эхлэхийн өмнө, завсарлагаагаар сонсгож анхааруулж ажиллаж байна. “Аудио бичлэг”-ийг 200,000 гаруй үзэгч, үйлчлүүлэгчдэд сонсгож анхааруулж ажиллалаа

Үүнд:

- Хотын соёлыг түгээн дэлгэрүүлэх, үзэгчдийн үзвэр үзэх соёлыг дээшлүүлэх зорилгоор үзвэр, хурал арга хэмжээ эхлэхийн аудио санамж бичлэгийг үзэгч үйлчлүүлэгчдэд тогтмол хүргэн ажиллаж байна.
- Үзвэрийн танхимд ус ундаа, хүнсний бүтээгдэхүүн хэрэглэхийг хориглосон санамжуудыг байршууллаа.
- Их танхимд үзвэрийн өмнө ба дараа агаар сэлгэлт тогтмол хийж, цэвэрлэгээ үйлчилгээг халдваргүйжүүлэх бодис уусмал ашиглан халдвар хамгааллын дэглэмийг сахин чанартай гүйцэтгэж байна.

3.2 Байгууллагын менежментийг боловсронгуй болгох, өмчийн ашиглалтыг сайжруулах талаар:

Өргөө нь байгууллагын дүрмээр хүлээсэн “Нийслэлийн өмчийн барилга байгууламж, эд хөрөнгийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад түрээслүүлэх” үүргээ хангалттай хэрэгжүүлж ажиллаж байна.

Инженер техникийн албаны албан хаагчид 2023 онд “А”, Б, “Г” байрны өрөөнүүдэд, фоейнд солих шаардлагатай 55 радиаторуудыг өөрийн урсгал зардлын төсвөөс худалдан авч мөн түрээслэгч байгууллагуудын худалдан авч өгсөн 26 паарыг сольж суурилуулан тавилаа.

“А” байрны 1, 2, 3 давхар, коридор, ажлын өрөөнүүд, Г байрны 1 давхрын хүлээлгийн хэсэг, үзэгчдийн хүлээлгийн заал, үзэгчдийн хүлээлгийн заалны гонхтой хэсгийн өндөр таазны прожектор суурилуулан нийт 13469 м/кв талбайн гэрэл


гэрэлтүүлгийг солих сэлбэх, эвдрэл гэмтлийг засаж сайжруулан ажлын орчин нөхцөл, ая тухтай нөхцөл бололцоог ханган ажиллаа. Мөн Инженер техникийн албаны ажилчид түрээслэгч байгууллагуудын цахилгаан шугамын гэмтэл, эвдрэл, гэрэл разетка солих, үйл ажиллагаанаас хамаарч гадна талбайд цахилгаан татах, тоглолт арга хэмжээний ЛЭД дэлгэцийг цахилгааны эх үүсвэрээр хангах зэрэг шуурхай засвар үйлчилгээг хийж нийтдээ 1100 гаруй удаагийн дуудлаганд явж ажилласан байна.


Мөн цахилгааны хэвийн үйл ажиллагааг доголдолгүй хангах үүднээс цахилгааны сэлгэн залгалтын 2000 ампертай 6 ширхэг катушка шинэчлэн сольж сайжруулан СТӨргөөнд явагдаж байгаа үйл ажиллагааг ямар нэгэн цахилгааны саатал доголдолгүй ажиллах боломжийг хангаж ажиллав.


Инженер техникийн албаны ажилчид босоо болон хэвтээ шугамын цэвэр, бохир усны шаардлага хангахгүй болсон цоорсон труба, холигч, радиатор, суултуур, тосгуур, шугамын хаалт, төмөр хоолой, холбох хэрэгслийг сольж дулааны хэвийн үйл ажиллагааг хангаж ирлээ. Түрээслэгч байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг доголдуулалгүй дулаанаар хангах, цэвэр бохир усны найдвартай хэрэглээ, усны алдагдалгүй зохистой хэрэглээг хянаж нойлын суултуур, угаалтуурын ус алдагдлыг засварлах, бохирын шугам хоолойны бөглөрлийг гаргаж нийтдээ 953 удаагийн дуудлаганд засвар үйлчилгээ үзүүллээ.

2007 оноос хойш АН-ын байрыг нураахад ажиллагаагүй болсон бохирын шугам хоолойн гэмтлийг 3 м гүн, 10 метрийн урттай шороо шуудууны ажлыг хийн гэмтсэн шугамыг шинээр сольж, төвийн бохирын хоолойнд холбон олон жил ажиллахгүй байсан “А” байрны урд хэсгийн үзэгчдийн ариун цэврийн өрөөг хэвийн үйл ажиллагаанд оруулан нийт 12 тасалгааг ашиглалтад оруулж үйлчлүүлэгчдийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлж ажиллаа. Мөн “Ус суваг”-ийн удирдах газартай хамтарч Өргөөний хойно байрлах 18 бохирын худгийн лагийг цэвэрлэж, үлээлгэх ажил хийгдэн дулаан болон сантехникийн шугам хоолойн үзлэг шалгалтыг ИТА-ны ажилчид тогтмол гүйцэтгэж ажиллаа.


“Г” байрны ачааны 1, хүн зөөврийн 3 лифтний ашиглалтын хугацаа дуусаж эвдрэл гэмтэл, гацах тохиолдлууд их гарч, сэлбэг хэрэгслийн олдоц муу байдаг ч өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан засвар үйлчилгээг хийн ажиллаж байна.





























Барилгын засвар үйлчилгээ




Өргөөний А, Б, Г байр, үзэгчдийн их танхим, 45 түрээслэгч байгууллагын оффисын өрөө, тасалгаа, коридор болон шат, тааз, хананд обой наах, эмульсдэх, паркетан шал суулгах, будах засвар үйлчилгээний ажлуудыг хийж өмчийн байрны ашиглалт хамгаалалтыг сайжруулан ажиллалаа.

Үүнээс дурдвал: Их танхимд үзэгчдийн сандал засварлах, тайзны арын коридорын обойг шинэчлэх, үйлчилгээний ажилчдын өрөөг будах, төв хаалганы 1 давхрын үүдний хэсгийн ханыг шинээр эмульсдэх, ажилчдын хаалганы шатны 2 талын халцарч хуурсан будгийг замаск татан өнгийг сэргээж, үзэгчдийн хаалганы тулгуур өндөр баганыг будах, шавардах, хаяавч чулуу эмтэрч хагарсныг шинээр сольж шинэчлэн ажиллаа. Мөн объектын дулаан алдалтыг бууруулан дулаан алдалт их байдаг хуучирч муудсан цонхнуудыг шинэчлэх, хаалга солих, түрээслэгч байгууллагуудын дуудлагаар засвар үйлчилгээг цаг алдалгүй гүйцэтгэж ирлээ.

СТӨргөө нь өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээ хийхээс гадна зориулалтын ариутгалын бодис уусмалаар, ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж А, Г корпусын оффисийн өрөө тасалгаанууд, их танхим, уран бүтээлчдийн өрөө, агуулах, зоорийн давхрууд болон үүдний угтах хэсгийг ариутгаж нийтдээ 13,469 м/кв талбайд ариутгал халдваргүйжүүлэлтийг жилд 3 удаа тогтмол хийж хэвшсэн байна.











Өргөөний уран бүтээл техникийн алба нь захиалгат тоглолт, уран бүтээлийг үзэгчдэд хүргэхийн тулд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.



- Техникийн бүрэн бүтэн байдал аюулгүй ажиллагаанд анхаарч трестрийн өрөөний цахилгаан хангамж шатсан автоматууд, кабелиудыг солих
- Их танхимын тайзны төв хөшигний тасарч муудсан троссыг шинэчлэн сольж 100 метр тросс мөн хязгаарлагч сольж
- Штангет, хөгжмийн яамны өргөгч төхөөрөмжүүдийн тосолгоо үйлчилгээг хийх
- Хөгжим, гэрэлтүүлэг, техник тоног төхөөрөмжүүд болон декарац, галерей, өрөө тасалгаануудад нэг бүрчлэн цэвэрлэгээ үйлчилгээг бүрэн хийж гүйцэтгэлээ.

Уран бүтээл техникийн алба нь тоглолт арга хэмжээний техникийн бүрэн бүтэн байдлыг ханган тайзны хөшиг, сафет, дуу дуугаралтын тоног төхөөрөмж, уран сайхны гэрэл, ложны венусны гэрэл, цахилгааны аюулгүй ажиллагаа, тоног төхөөрөмжинд шаардлагатай үйлчилгээ, техникийн үзлэг шалгалтуудыг хэвшүүлэн хийж гүйцэтгэж ажиллаж ирлээ.









3.3 Төсвийн орлогын бүрдүүлэлт, төвлөрүүлэлтийн тухай.

Манай байгууллага түрээсийн буюу үзвэр үйлчилгээ, арга хэмжээний орлогоор үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлж, батлагдсан төсөв, үр дүнгийн гэрээний хүрээнд зардал гарган, төсвийн санхүүжилтийг үр ашигтай зарцуулж, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэж, хуулийн хугацаанд тайлагнаж ирлээ.


2023 оны жилийн эцсийн байдлаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нийлсэн **127** түрээслэгчтэй түрээсийн гэрээ байгуулан, гэрээний биелэлтийг хангуулж, НИТХ-аас баталсан төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааны зардлаа санхүүжүүлж, төсвийн сахилгыг чанд сахиж ажиллалаа.

Өргөө нь Нийслэлийн өмчийн байрны түрээс болон тоглолтын орлогоос нийт **2,509,606,326.05** төгрөгийн орлогыг бүрдүүлэн, Нийслэлийн төсвөөс **436,006,936.76** төгрөгийн санхүүжилт авч байгууллагын үйл ажиллагааны зардлаа **2,204,036,536.76** төгрөгөөр санхүүжүүлж, батлагдсан төлөвлөгөөний дагуу нийслэлийн төсөвт 2023 онд төвлөрүүлэх ёстой орлогыг НӨХГ-т **392,367,889.52** төгрөг, УБХХК-д **89,141,806.2** нийт **481,509,695** төгрөгийг төвлөрүүлсэн. Мөн давуулан биелүүлсэн тоглолтын орлогоосоо Нийслэлд **260,067,030.33** төгрөг төвлөрүүлж нийт 2023 онд Нийслэлийн төсөв **741,576,726.05** төгрөг төвлөрүүлэн ажиллалаа.

Нийслэлийн Соёлын Төв Өргөөний 2000-2023 онд бүрдүүлсэн орлого, төсөвт төвлөрүүлсэн, үйл ажиллагааг санхүүжүүлсэн мөнгөн хөрөнгийн тооцоо

Д/д	Он	Нийт бүрдүүлсэн орлого	Зарлага		Захирамжа ар /мян.төг/	Төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө	Хувь
			Зардал санхүүжүүлэ	Төвлөрүүлсэн орлого			
1	2000	565,261.60	376666.6	188595		171419.7	110
2	2001	789,100.50	576733	212367.5	10,500.00	176391.7	120.4
3	2002	730,734.70	544884.7	185850	16,950.00	185524.8	105.3
4	2003	704,033.90	496433.9	207600	43,000.00	206400	105.6
5	2004	983,306.70	708514.7	274792	24,050.00	210993.7	135.4
6	2005	1,120,315.80	856616.4	263699.4	87,150.00	263699.4	106.4
7	2006	1,287,005.20	929403.2	357602	98,350.00	345291.8	103.6
8	2007	1,513,564.60	1050507.7	463056.9	6,225.00	375009.6	171.5
9	2008	1,464,915.50	1100407.2	364508.2	50,750.00	364449.2	100
10	2009	1,267,699.40	1017699.4	250000	74,400.00	249340.6	100.3
11	2010	1,388,227.80	1108227.8	280000	88,750.00	280006.2	100
12	2011	1,552,116.90	1239008.6	298428.8	78,575.00	298428.8	100
13	2012	1,694,306.20	1782669.5	450000	44,162.50	304031.9	148
14	2013	1,637,720.60	1372057	380000	147,500.00	377545.2	100.7
15	2014	1,659,664.50	1252664.4	407000	104,500.00	406027.6	100.2
16	2015	1,580,607.10	1157707.1	422900	89,500.00	422000	100.2
17	2016	1,564,740.40	1202740.4	362000	102000	361093.7	100.3
18	2017	1,476,899.40	1109974.5	361247.8	161500	361247.8	100
19	2018	1,396,156.00	1070462.3	325693.7	168500	325193.2	100
20	2019	1,665,383.40	1319455.6	332000	295000	332000	100.2
21	2020	963,758.10	1078049.2	24933.9	49000	0	
22	2021	1,222,439.70	1,113,133.70	109,306.10	112,750.00	151,696.70	72,0
23	2022	1,515,292,8	1,323,227.90	235,000.00	192,000.00	210,841,5	128
24	2023	2,945,613.20	2,204,036.50	741,576.70	200,000.00	322,626.50	229
	Дүн	31,173,571.20	25,991,281.30	7,498,158.00	2,245,112.50	6,490,418.10	

Нийслэлийн соёлын төв өргөөний 2000-2023 онд бүрдүүлсэн орлого, төсөвт төвлөрүүлсэн, үйл ажиллагааг санхүүжүүлсэн мөнгөн хөрөнгийн тооцоог графикаар харуулвал:



3.4. Албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах талаар дараах ажлуудыг хийлээ.

Албан хаагчдын эрүүл мэнд, ажлын байрны нөхцөл сайжруулах, сургах, мэргэшүүлэх, үйлчилгээ, харилцааны соёл эзэмшүүлэх, хүний нөөцийн судалгаа, албан хаагчдын хувийг хэргийг жил бүр шинэчлэн өөрчлөх, бүрдүүлэх, мэдээллийн ил тод байдлыг хангах, зэрэг олон ажлыг үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгаж, хэрэгжүүлж хэвшлээ. Тухайлбал:

3.4.1 Хүний нөөцийг хөгжүүлэх идэвхжүүлэх чиглэлээр:

3.4.1.1 Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэхээр зохион байгуулсан сургалтад нийт 4 сургалт, зөвлөгөөнд 68 албан хаагч (давхардсан тоогоор) хамрагдлаа. Үүнээс туршлага солилцох, санал хүргүүлэх зөвлөгөөнд 3 албан хаагч оролцсон байна.

1. "Улаанбаатар 2023" Зүүн Азийн залуучуудын наадмын "е-спорт" төрлийн тэмцээн Өргөөнд зохион байгуулахаар шийдвэр гарсантай холбогдуулан "ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийх" сэдэвт сургалт арга хэмжээг Нийслэлийн онцгой байдлын газартай хамтран 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 09.00-13.00 цагийн хооронд зохион байгуулав. Сургалтад Өргөөний бүх ажилтан албан хаагчид хамрагдав.



2. Байгууллагын хүсэлтийн дагуу Төр, захиргаа үйлчилгээ эрхлэх газрын мэргэжлийн үйлчлэгч бэлтгэх сургалтын төвийн багш н.Энхтөр Маркетинг үйлчилгээний албаны албан хаагчдад “Харилцааны ёс зүй” сэдвээр хичээл орлоо.



3. Мэргэшсэн нягтлан бодогчдын институтийн зохион байгуулагддаг сургалтад ерөнхий нягтлан бодогч Ө.Цолмон суралцаж, эрхийн шалгалтыг амжилттай хамгаалав. Санхүү, менежментийн албаны 4 албан хаагч худалдан авах ажиллагааны АЗ-ын сургалтад цахимаар хамрагдаж байна.

4. Нийслэлийн Архивын газраас 3 өдрийн ажлын байран дахь дадлагажуулах сургалт 11 дүгээр сарын 21,22,23-ны өдрүүдэд мөн Нийслэлийн Архивын газраас 2023 оны 12 дугаар сарын 08-нд “Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ-тай хамтран “Архивын хадгаламжийн нэгж бүрдүүлэх, данс бүртгэл хөтлөх, архивын баримтын хадгалалт хамгаалалт” сэдэвт үзүүлэх сургалтад тус тус байгууллагын архив, бичиг хэрэг хариуцсан ажилтан Ү.Баярбатыг хамруулан ажилласан.

5. Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооноос зохион байгуулсан “Ажил амьдралын тэнцвэрийг хангаж буй талаарх Японы туршлагыг танилцуулах нь” сэдэвт сургалтад Хүний нөөцийн ажилтан 09 сарын 13,14-ний өдрүүдэд хамрагдав.

6. Мэргэшсэн нягтлан бодогчдын институтээс зохион байгуулсан “эд хариуцагчийн сургалт”-ын 18 цагийн хөтөлбөрт Санхүүжилт менежментийн албаны 2 нярав суралцсан байна.

3.4.1.2 Албан хаагчдыг байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр гадаад сургалтад хамруулаагүй.

Дэлхийн улс орнуудад тархаад байгаа “Коронавирус /COVID-19/ цар тахлын улмаас Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу “Төрийн хэмнэлтийн тухай” хуулийн хэрэгжилтийн хүрээнд (15.2.3.сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;) зарим зардлыг хэмнэж, мэргэшүүлэх

сургалтад хамрагдах албан хаагчийг хувийн зардлаар нь сургахаар төлөвлөгдсөн байна.

3.4.1.3 Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт, хөдөлгөөнийг авч үзэхэд

- Албан хаагчдыг томилсон, чөлөөлсөн хөдөлгөөний тайлангаар 2023 онын 01 дүгээр сарын 01-ний байдлаар нийт 54 албан хаагч ажиллаж байсан бол 2023 онын 12 дугаар сарын 28-ны байдлаар 56 албан хаагч ажиллаж байна.
- Албан тушаалын тодорхойлолтын шаардлагыг хангасан хүний нөөцийн ажилтан, тайзны тоног төхөөрөмжийн засварчин, үйлчлэгч, гадна талбайн үйлчлэгч нарын 12 иргэнийг ажилд томилж, 1 ажилтан тэтгэвэр тогтоолгохоор, 9 албан хаагч өөрийн хүсэлтээр ажлаас тус тус чөлөөлөгдсөн байна.

3.4.2 Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр:

3.4.2.1 Албан хаагчдын цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэхэд цалинд 782,028.9 мянган төгрөгийг, хавсран ажилласны хөлсөнд, төрийн алба хаасны, ур чадварын, илүү цагийн, шөнийн нэмэгдэлд 227,416.7 мянган төгрөгийг, хоол унаанд 129,309.1 мянган төгрөгийг, үр дүнгийн урамшуулалд 147,680,1 мянган төгрөгийг тус тус олгож, нийт 1,286,434.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.


3.4.2.2 Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр хамт олноос санал авч, дараах ажлуудыг хийлээ.

➤ Албан хаагчдыг тав тухтай орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлж Их танхимын тайзны хажуу талын агуулахын 128 тоот өрөөг Уран бүтээл, техникийн албаны тайзны ажилтан, албан хаагчдад засаж, тохижуулан орчин нөхцөлийг нь сайжруулан ажиллаа.

➤ Маркетинг үйлчилгээний албаны үйлчилгээний албан хаагчид “А” байрны 1 давхарт агааржуулалт байхгүй жижиг өрөөнд байрлаж байсныг “А” байрны урд жигүүрт байрлах хуучин ээлжийн диспетчерүүд байрлаж байсан 2 цонхтой, агааржуулалт сайтай өрөөг тохижуулан ажиллагсдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулж ажиллалаа.

➤ Маркетинг үйлчилгээний албаны “Г” байрны оффисын үйлчилгээний албан хаагчдын ая тухтай ажиллах орчин нөхцөлийг сайжруулан 1 давхарт өрөө гаргаж, өрөөний ханын нүхний цоорхой хэсгийг кнапдаж бөглөн дээр нь замаск татаж, таазыг цагаанаар, ханыг цайвар шаргал өнгөөр эмульсдэж, ажиллах орчныг сайжруулахад анхаарч ажилласан.

➤ Албан хаагчдын ая духтай ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, эрүүл мэндийн боловсролыг олгох, эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэхээр албан хаагчдад зориулан амрах болон, биеийн тамирын дасгал хөдөлгөөн хийх, жендерийн эрх тэгш байдлын үүднээс бага насны хүүхдүүдтэй ээж, аав нарт зориулж хүүхдийн булан тохижуулж, өрөөг өөрсдийн урсгал засвараас тохижуулан ашиглалтад орууллаа.



3.4.3 Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр

1. НСУГ-аас санаачлан зохион байгуулсан спортын 5 төрлийн тэмцээнд Нийслэлийн Соёлын Төв Өргөөний баг хамт олон биллиард эмэгтэй алт, дартсын багийн төрөлд хүрэл, гар бөмбөг хүрэл, багийн нийт амжилтаар III байр эзлэн амжилттай оролцсон.



2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн, Биеийн тамир, спортын тухай хууль, “Алсын хараа-2050” мөрийн хөтөлбөр, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд идэвхтэй хөдөлгөөн, эрүүл амьдралын хэвшил бүхий иргэн, биеийн тамир, спортоор хичээллэх ач холбогдлыг ойлгуулах мэдлэг, мэдээлэл олгох, эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэхээр Нийслэлийн Соёлын төв өргөөний хамт олон “Цаг гаргая” аянд спортын 9 төрлөөс дараах төрлүүдийг сонгон нэгдэв.

- Иогийн төрлийг сонгон авч аяны хугацаанд тууштай хичээллэв. Иогоор 2 сарын

хугацаанд 7 хоногт 2 удаа Монголын Иогийн Холбооны удирдах зөвлөлийн гишүүн Иогийн багш Б.Тэгшбадрах багшаар хичээл заалгаж, цаашид үргэлжлүүлэн хичээллэж ажлын байран дээрээ эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэхээр боллоо.

- Алхах нь хөдөлгөөний дутагдлаас сэргийлэхээс гадна, цусны эргэлтийг сайжруулж

зүрх судасны үйл ажиллагаанд эерэг нөлөөтэй тул Шар хоолойн аманд байрлах уулын оргил өөд алхалт хийв.

Гимнастик хийх нь хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх ач холбогдолтой. Аяны хүрээнд алба, албаараа хийж буй гимнастикаа хийж, ажлын байран дээрээ тогтмол хийхийг уриалав.







3. Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэгт Төрийн тусгай албан хаагчдын эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээний байгуулан багц шинэжилгээнд хамруулж, шаардлагатай албан хаагчдыг нарийн мэргэжлийн эмчийн үзлэг оншилгоонд хамруулж ажиллаж байна. Нийт албан хаагчдийн 85 хувь нь хамрагдсан байна.



3.4.4 Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал.

Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын хэрэгжилтийг хангаж, 2023 онд өндөр насны тэтгэвэр тогтоолгосон 1 албан хаагчид IV улиралд 16,477,500 төгрөгийг, гачигдлын улмаас 6 албан хаагчдын ар гэрт 3,000,000 төгрөгийн тусламж, 1000,000 төгрөгийн буцалтгүй тусламж 2 албан хаагчид, “Эх үрсийн баяр”-ийн өдөр албан хаагчдын хүүхдүүдийг баярлуулах бэлгэнд 2,838,400 төгрөг, байгууллагаас гавьяаны амралтанд гарсан 31 өндөр настангуудад хүндэтгэл үзүүлж 3,100,000 төгрөг нийт 26,415,900 төгрөгийг олгосон байна.

3.4.5 Албан хаагчдын ажлын сахилга, хариуцлагыг сайжруулах, ил тод байдлыг хангах чиглэлээр.

- 2023 оны албан хаагчдаас ёс зүйн зөрчил гаргаагүй болно.
- Ажлын байрны сул орон тооны зар, хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, албан хаагчдын ёс зүйн дүрэм, “Албан хаагчдын дагаж мөрдөх хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм”, албаны “Албан хаагчдын дагаж мөрдөх хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны журам”-ыг цахим хуудас, мэдээллийн самбарт байрлуулсан байдаг.
- Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг албадын үйл ажиллагааны онцлогийг харгалзан, албадын ажлын тайланг алба, нэгж бүрээр захирлын зөвлөлийн хурлаар оруулан хэлэлцүүлж, ажлын гүйцэтгэлийг нь дүгнэж, хэвшсэн. Улмаар албадын үйл ажиллагааны чиглэлээр нийт ажилчдын саналыг сонсож, жилийн эцсээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.
- Байгууллагын албан хаагчдын ажлын бүтээмж, хариуцлагыг нэмэгдүүлэх, үйлчилгээний ажилчдын хандлага, харилцааны соёл, ёс зүй, үйлчилгээний чанарыг сайжруулан хэвшүүлэх зорилготой **“Соёлтой үйлчилгээ-Чанар-Хариуцлага”** аяныг 2023 оны 03 дугаар сарын 20-ноос 04 дүгээр сарын 20-ны хооронд зарлаж, цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулан ажиллаа

3.4.6 Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах чиглэлээр

- 2023 он жилийн эцсийн байдлаар Төрийн дээд одон-1, Соёлын яамны тэргүүний ажилтан-2, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны “Тэргүүний ажилтан” -4, Эрчим хүчний яамны “Тэргүүний ажилтан”-аар 2, Нийслэлийн шагналаар-2, Санхүү банкны “Тэргүүний ажилтан”-1, Яамны жуух бичгээр-9 Залуучуудын холбооны шагналаар - 4 ажилтан нийт 25 албан хаагч шагнуулсан байна.

3.5 Архив, албан хэрэг хөтлөлт, хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн талаар дараах ажлуудыг хийлээ. Үүнд:

www.edoc.ulaanbaatar.mn-ийг ашиглан:

Нийслэлийн байгууллагуудад иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн албан бичиг шийдвэрлэхэд ашиглагдаж буй www.edoc.ub.gov.mn цахим программаар:

Ирсэн албан бичиг: Тайлант хугацаанд нийт 118 албан бичиг ирснээс 67 хариутай бичгийг хүлээн авч тухай бүрд нь холбогдох албан тушаалтанд танилцуулж хугацаатай албан бичгийн хариуг хугацаанд нь явуулсан.

Явуулсан албан бичиг: Тайлант хугацаанд нийт 128 албан бичиг явуулсан. Үүнээс 10 хариутай бичиг, 118 хариугүй албан бичгийг тус тус явуулсан.

www.erp.ulaanbaatar.mn-ийг ашиглан:

Өргөдөл гомдол: Ажилтнуудаас хандсан өргөдөл нийт 18-г хүлээн авснаас ажилд орох хүсэлт 10, ажлаас чөлөөлөгдөх хүсэлт 4-г хүлээн авсан.

Тушаал: “Б” тушаал 45 гарснаас үүнээс ажлаас чөлөөлөх 7, ажилд томилох 10, урамшуулал олгох тухай 4, буцалтгүй тусламж олгох 8, ээлжийн амралт эдлүүлэх тухай 1 тушаал гарсан байна. Үндсэн үйл ажиллагаатай холбоотой “А” тушаал 24 гаргаж, хэрэгжүүлсэн байна.

ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ.

4.1 Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж, төсвийн хөрөнгийн батлагдсан төлөвлөгөө, зарцуулалтын сар улирлын мэдээ, тайлан балансыг Нийслэлийн төрийн санд өгч, шилэн дансанд тухай бүр байршуулж, байгууллагын сайтад тавьж нийтэд толилуулж ирлээ.

Мөн түрээсийн буюу үзвэр үйлчилгээ, арга хэмжээний орлогоор үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлж, батлагдсан төсөв, үр дүнгийн гэрээний хүрээнд зардал гарган, төсвийн санхүүжилтийг үр ашигтай зарцуулж, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэж, хуулийн хугацаанд тайлагнаж хэвшлээ.

4.2 Үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, дараах ажлуудыг хийж, хэвшүүлээ.

4.2.1 Нийслэлийн Засаг даргын “Мэдээллийн ил тод байдлыг хангах талаар авах

зарим арга хэмжээний тухай” 2012 оны А/606 дугаар захирамжийн дагуу байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг цаг тухайд нь цахим сайтад байршуулан, ил тод байдлыг хангаж ажиллаж ирлээ. /2022 оны аудитыг үнэлгээ, захирлын А тушаал, ирсэн бичгийн шийдвэрлэлтийн мэдээ, хөрөнгө худалдаж авсан мэдээлэл, 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, 2023 оны үйл ажиллагааны тайлан, ажлын байрны зар, шинээр ажилд орсон болон гарсан албан хаагчдын хөдөлгөөний мэдээ зэргийг байршуулж ажиллалаа.

Мөн цаг үеийн мэдээллийн самбарыг ажилд оруулж өдөр тутмын ажил, тоглолтын график, ажлын дуудлага байрлуулж өдөр, тутмын шинэ мэдээ мэдээллээр хангаж, байгууллагын сайтыг тогтмол ажиллуулж хэвшүүлээ.

4.2.2 Үйлчилгээний ажлын ил тод байдлыг хангах зорилгоор санал, хүсэлт, сэтгэгдлийг нийтийн ариун цэвэр, угтах үйлчилгээ, үйлчилгээний ажилтны харилцааны соёлын чиглэлээр сэтгэл ханамжийн асуулгыг түрээслэгч байгууллагуудаас 6 чиглэлийн асуулга хуудсаар авч, судалгааны дагуу албан хаагчдад мэдээлэл хүргэгдэж байна. Их танхимын түрээслэгч байгууллагаас Нийслэлийн Засаг Даргын Тамгын газраас ирүүлсэн чиглэлийн дагуу QR код уншуулан сэтгэл ханамж, үйлчилгээний талаар судалгааг авч ажиллаж байна.

4.2.3 Мөн байгууллагын ил тод байдлын хэрэгжилтийн хүрээнд Нийслэлийн Засаг

даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст 7 хоногийн Пүрэв гаригт үйл ажиллагааны мэдээг, Баасан гариг бүр ил тод байдлыг хангаж цахим хуудсанд байршуулсан мэдээллийг 2023 оны I,II улиралд хүргүүлэн ажилласан. Мөн III, IV улиралд Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн Төрийн үйлчилгээний шийдвэрлэлтийн хяналт хариуцсан ажилтан Б.Удвалд 7 хоногийн Баасан гариг бүрт Их танхимд зохион байгуулагдаж буй арга хэмжээний мэдээллийг хүргүүлж байна.

4.3 Хүний нөөцийн бодлогын ил тод байдлыг хангаж дараах ажлуудыг хийлээ.

4.3.1 Албан хаагчдын ёс зүйн дүрмийг болон ажлын байрны сул орон тооны зарыг цахим хуудас, мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулж, тухай бүрд нь шинэчилж байна.

4.3.2 Хөдөлмөрийн тухай хуулийн өөрчлөлттэй холбогдуулан 2022-2026 оны Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг мөрдөж, таниулан ажиллаж байна.

4.3.3 Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг албадын үйл ажиллагааны онцлогийг

харгалзан, албадын ажлын тайланг алба, нэгж бүрээр захирлын зөвлөлийн хурлаар оруулан хэлэлцүүлж, ажлын гүйцэтгэлийг нь дүгнэж ажиллалаа.

4.4 Байгууллагын гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилтын хүрээнд дараах ажлуудыг хийлээ.

4.4.1 Хятад Орныг Танин Мэдэх” Өвөр Монголын Соёлын Өдрүүдийн хүрээнд зохион байгуулагдаж буй Хэннэн мужийн “Зэвсгийн Эрдэм” Шаолинь Үшүгийн тусгай тоглолт 2023 оны 08 дугаар сарын 30,31-ний өдрүүдэд болж өнгөрөв.

4.4.2 Орос–Монголын найрамдал, хамтын ажиллагааны 63 дахь өдрүүдийн хүрээнд зохион байгуулагдсан Буриад Улсын алдарт Байгал чуулга, Буриадын Дуурийн театрын алдартай дуучид, балетын бүжигчид, рок попын уран бүтээлчдээс бүрдсэн 160 гаруй хүний бүрэлдэхүүнтэй “Найрамдал” тоглолт амжилттай болж өндөрлөлөө.

Энэ хүрээнд Буриад Улсын Соёлын сайд Дагаева Соёлма Баяртуевна хүрэлцэн ирж Нийслэлийн Соёлын төв Өргөөний захирал Д.Ариунбаатартай уулзаж, цаашид ажиллах хамтын ажиллагааны талаар санал солилцлоо.



ТАВ. ЦАГ ҮЕИЙН ШААРДЛАГААР ХИЙСЭН АЖЛЫН ҮР ДҮН.

5.1. Улс, Нийслэл, дүүргийн удирдлагаас ирүүлсэн шийдвэрийн хэрэгжилт.

Дээд газраас ирүүлсэн болон Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Онцгой комисс, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын албан тоот, Улаанбаатар хотын ерөнхий менежерийн албан тоот зэрэг нийт **63** шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажилласан болно.

5.2. Нийслэл, дүүргийн удирдлагаас цаг үеийн асуудлаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт.

5.2.1 Нийслэл Засаг даргын 2022 оны “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” А/1357 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд шинээр байгуулагдсан Чингэлтэй дүүргийн 23 дугаар хорооны хэсгийн дарга Х.Үзмээтэй хамтран тус нутаг дэвсгэрт байрлаж буй сайжруулсан шахмал түлшний борлуулалтын 5 цэгт хяналт тавьж, байгууллагын албан хаагчид ээлжлэн хяналтаар явж ажилласан.




Сайжруулсан шахмал түлшний борлуулалтын цэгүүдийн хоногийн мэдээг цаг хугацаанд нь Чингэлтэй Дүүргийн Тамгын газрын Агаар орчны бохирдолтой тэмцэх газрын тасгийн дарга н.Буянчимэгт 2023 оны 04 дүгээр сарын 01-ны өдөр хүртэл хүргүүлэн ажиллаа.

5.2.2 “Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын дэд систем”-ийг ашиглалтад оруулж байгаатай холбогдуулан Засгийн Газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журмыг үндэслэн 2023 оны 03 дугаар сарын 25-ны дотор Байгууллагын стратеги төлөвлөгөө боловсруулан Нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлэх чиглэл ирсний дагуу хэрэгжилтийг хангаж ажиллаа.

5.2.3 Өргөө нь Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2023 оны А/01 дугаар тушаалаар Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн их цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах хуваарь батлагдсаны дагуу 2023 оны 02 сарын 17 ны өдрийн сар шинийн баярын өдрийг угтаж “Хоггүй шинэлье” бүх нийтийн цэвэрлэгээнд маркетингийн үйлчилгээний албанаас СТӨ-ний “Г” хэсгийн зоорийн давхрын болон агуулах, АТС-ын өрөө тасалгаа, хуримтлагдсан хогийг цэвэрлэв. “А” хэсгийн нийтийн ариун цэврийн өрөө, тамхины өрөө, агуулахын өрөөний шороо тоосыг цэвэрлэн хогийг ачуулав. Үйлчилгээний ажилчид өөрсдийн хариуцсан гадна талбай болон их танхимын сандал, хивсэнцэр , фойеоны дубыг өнгөлж, хивсэнцэртээ их цэвэрлэгээ хийж, 2023 оны 04-р сарын 14-ны өдрийн 10:00-13:00 цагийн хооронд “Хаврын их цэвэрлэгээ 90 минут” арга хэмжээнд нэгдэж, “Туул голын хойд хэсэг, маршалын гүүрнээс зүүн тийш 35 дугаар шон хүртэл” ойр орчныхоо хог хаягдлыг цэвэрлэн бүх нийтийн хаврын их цэвэрлэгээний ажилд байгууллагын нийт ажиллагсад идэвх зүтгэлтэй хамрагдлаа.





5.2.4 Өргөө нь Монгол Улсын Ойн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлигийн хүрээнд хэрэгжүүлэх “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Ногоон хот–Иргэний оролцоо” хаврын мод тарих аянд нэгдэж, ХУД-ийн 14 дүгээр хороо Айдсын аманд 2022 онд 51 нүхэнд (улиас 15 ширхэг, хайлаас 92 ширхэг) нийт 107 ширхэг мод тарьсан байна.

Энэ жил 2023 оны 05 дугаар сарын 14-нд “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тарьсан 107 модны ойр орчмын шарилж өвсийг цэвэрлэж, модны ургацын байдлыг сайжруулж, усалгаа тордолт хийв.





5.2.5 Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Шадар сайдын ажлын алба, Онцгой байдлын ерөнхий газраас Стратегийн команд штабын сургуулийг анх удаа 2023 оны 06 сарын 08-ны 16:00 цагт орон даяар гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулийг зохион байгуулж, НЗД-ын А/194 дүгээр захирамжийн дагуу манай байгууллага заавар, зөвлөмжийн дагуу оролцлоо.



5.2.6 Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2.7.2 дахь заалтыг үндэслэн хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдийг орчны эрсдэлт нөхцөлд өртөх, осол гэмтэлд орохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийн өмнө үүрэг хүлээсэн хэн бүхэн орчны эрсдэлийг бууруулах, хүчирхийлэл, дарамт, хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хүрээнд шалгах, мэдээлэх, эрсдэлийг бууруулах, орчныг ээлтэй болгох эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн "Нэгдүгээрт Хүүхэд" нэгдсэн аянд 2023 оны 06 дугаар сарын 12-ноос 06 дугаар сарын 16-ны хооронд нэгдсэн. Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор байгууллагын эцэг эхийн зөвлөлийг 2022 оны 03 дугаар сарын 30-ны Захирлын А/21 тоот тушаалаар шинэчлэн баталсан байна. Манай байгууллага аяны хүрээнд:

- Албан хаагчдынхаа хүүхдүүдийг аав, ээжийнх ажлын газартай танилцуулах өдөрлөг зохион байгуулсан.
- Монголын Уран Зургийн Галерей үзэв
- Морин хуурын чуулгын “Best of Playing love” тоглолт үзсэн.
- [#НЭГ_ДҮГЭЭРТ_ХҮҮХЭД](#) #НЭГДҮГЭЭРТ_ШАЛГА хаш таг ашиглан олон нийтийн цахим сүлжээнд байршуулав.
- “HUGMOM” сэтгэлзүйн төвийн сэтгэл зүйч Б.Батчимэгийг урьж “Өөрийгөө танин мэдэх, сэтгэл хөдлөлөө яаж удирдах вэ? Цахим орчны хэрэглээний талаар сургалт, орж сонирхолтой яриа өрнүүлэв.
- Байгууллагын гадна орчинд эрсдэлийн үнэлгээ хийж, 2 зөрчил илрүүлж, аюулгүй байдлыг хангаж ажиллаа.









5.2.7 Улаанбаатар хотын ерөнхий менежер бөгөөд захирагчийн ажлын албаны даргын баталсан хуваарийн дагуу Нийслэлийн Соёлын Төв Өргөөний нийт 34 албан хаагч нийтийн эзэмшлийн гудамж, явган хүний замын цас цэвэрлэгээний ажлыг 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр “Жуковын хөшөөнөөс Монгол кино үйлдвэрийн гарц” хүртэл нийт 950м замыг цэвэрлэж дуусгалаа.





5.2.8 Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба, Ерөнхий менежерийн баталсан 2023.12.20 ны өдрийн 01/2422 албан бичгийн “Цасаа цэвэрлэе” аяны удирдамжийн дагуу Нийслэлийн Соёлын Төв Өргөөний ажилтан албан хаагчид нийтийн эзэмшлийн гудамж талбай болох Багшийн дээдээс ТИС, БНХАУ-ын Элчин сайдын яамны баруун тал, МУИС-ийн ЭЗСургууль хүртэлх явган хүний зам талбайн цас мөсийг цэвэрлэх ажлыг 2023 оны 12 сарын 22-ны өдөр хийж гүйцэтгэлээ.





5.2.9 2023.03.01-нээс 04 сарын 01-ний өдрийн хугацаанд “Жендерийн үндэсний хорооноос Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаарх ойлголт мэдлэгийг олон нийтэд хүргэх, эрэгтэй, эмэгтэйчүүдэд тулгарч буй жендерийн асуудлыг мэдээлэх, холбогдох төрийн байгууллагуудад хүргэх, олон нийтийн дуу хоолойг сонсох, асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлох “Харилцан хүндэтгэе” сарын аянд нэгдэж ажиллав.



2023.03.01-нээс 04 сарын 01-ний өдрийн хугацаанд “Жендерийн үндэсний хорооноос Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаарх ойлголт мэдлэгийг олон нийтэд хүргэх, эрэгтэй, эмэгтэйчүүдэд тулгарч буй жендерийн асуудлыг мэдээлэх, холбогдох төрийн байгууллагуудад хүргэх, олон нийтийн дуу хоолойг сонсох, асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлох “Харилцан хүндэтгэе” сарын аянд нэгдэж байна.



5.2.10 Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян"-ны "Хүндлэл хамгийн тод гэрэл" уриатай аянд албан ёсны сайт, facebook хуудас, PAGE хуудсанд "Хүндлэл бол хамгийн тод илрэл" уриатай постерыг байршуулан охид эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж байгаа гэмт хэрэг зөрчлийг арилгахад байгууллагын ажилчид нэгдэж, хүчирхийллийн хажуугаар дуугүй өнгөрөхгүй байхыг уриалж Нийслэлийн соёлын төв өргөөний ажилтан албан хаагчид нэгдэж ажиллаа.



ЗӨВШӨӨРСӨН:
ЗАХИРАЛ:

D. Ariunbaatar

Д.АРИУНБААТАР

ТАЙЛАН БИЧСЭН:
ХҮНИЙ НӨӨЦИЙН АЖИЛТАН:

Ch. Khishigsuren

Ч.ХИШИГСҮРЭН